



ТОМ НАР ЭНЕРЖИ ХХК

**“ТОМ НАР ЭНЕРЖИ” ХХК-НИЙ ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ, ЕСӨНБУЛАГ СУМ,
ХАРЗАТ БАГИЙН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ “10 МВТ ХҮЧИН ЧАДАЛТАЙ
ЭРЧИМ ХҮЧНИЙ ХУРИМТЛУУРЫН СТАНЦ” ТӨСЛИЙН 2025 ОНД
ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2025 он



“Том нар энерги” ХХК-ний “Говь-алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт хэрэгжүүлэх 10Мвт/42Мвт цагийн багтаамжтай эрчим хүчний батарей хуримтлуурын төсөл” –ийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

**“ТОМ НАР ЭНЕРЖИ” ХХК-НИЙ ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ, ЕСӨНБУЛАГ СУМ,
ХАРЗАТ БАГИЙН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ “10 МВТ ХҮЧИН ЧАДАЛТАЙ
ЭРЧИМ ХҮЧНИЙ ХУРИМТЛУУРЫН СТАНЦ” ТӨСЛИЙН 2025 ОНД
ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТЕРИЙН ДУГААР: 6357229

ХЯНАСАН:

ХБОБХГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

З. АЗЖАРГАЛ

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

“ТОМ НАР ЭНЕРЖИ” ХХК-НИЙ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Х. ТЭГШЭЭ

БОЛОВСРУУЛСАН:

ТОМ НАР ЭНЕРЖИ ХХК-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

Б. ГАНТӨГС

2025 ОН

ОРШИЛ

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний гол зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хэрэгжүүлж байгаа тодорхой төслийг хэрэгжүүлэх явцад тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгэм, оршин суугчдын эрүүл мэндэд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлох, үнэлэх, түүний сөрөг үр дагавар, түүнээс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг тогтоох явдал байдаг.

Том нар энерги ХХК-ний “Говь-алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт хэрэгжүүлэх 10Мвт/42Мвт цагийн багтаамжтай эрчим хүчний батарей хуримтлуурын төсөл”–ийн 2024 оны байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын хүрээнд уг төслийн үйл ажиллагааны үед байгаль орчин, нийгэм, нутгийн иргэдийн эрүүл мэндэд учруулж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга талаар хэрэгжүүлж ирсэн арга хэмжээг үнэлэхийн зэрэгцээ цаашид учирч болох нөлөөллийг тодорхойлох, уг сөрөг нөлөөллийг бууруулах, талаар авах арга хэмжээг тогтоох, төсөл хэрэгжүүлэгчид байгаль орчин, орчны тохижилттой холбоотой мэргэжил арга зүйн зөвлөмжүүдийг өгөх үндсэн чиглэлтэйгээр ажилласан.

Том нар энерги ХХК-ний “Говь-алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт хэрэгжүүлэх 10Мвт/42Мвт цагийн багтаамжтай эрчим хүчний батарей хуримтлуурын төсөл”-д БОУАӨЯ-ны шинжээч “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ын 2 дугаар хэсэгт заасан аргачлалын дагуу ерөнхий үнэлгээ хийсний үндсэн дээр уг төсөлд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай гэж үзсэн. Иймд төсөл хэрэгжүүлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий “Эртэч Наран” ХХК нь уг төслийн 2024 оны 04 сарын 30-ны өдрийн 24/34 тоот албан тоотоор баталгаажуулан БОУАӨЯ-аас гаргасан байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийг үндэслэн холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудыг баримтлан боловсруулсан.

Төслийн үйл ажиллагааны үед байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг агаар, хөрс, ургамал зэрэгт нөлөөлөх сөрөг нөлөөг бууруулахад чиглэсэн ургамлан бүрхэвчийн талхлагдал, хөрсийг бохирдол, элэгдлээс хамгаалах, агаарын бохирдлын нөлөөллийг бууруулах, хамгаалах зэрэг арга хэмжээний зөвлөмж, арга зүйг Монгол улсын стандарт, норм нормативд заасан шаардлагын дагуу тусгаж өгөв.

Эдгээр стандарт шаардлага, төлөвлөлт, хариуцлагын хүрээнд 2025 онд хэрэгжүүлэх ажлыг төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэв.

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Том нар энержи” ХХК-ний тухай

Төслийн нэр: “10 МВт хүчин чадалтай Эрчим хүчний хуримтлуурын станц”

Төсөл хэрэгжүүлэгч: “Том нар энержи” ХХК
Регистрийн дугаар 6357229
Улсын бүртгэлийн дугаар 9011813947

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо, Улаанхуаран 1
Утас: +976-9565-0580, +976-9526-1119 Имэйл: tomnarenergy@gmail.com


Төсөл хэрэгжих газрын байрлал: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Харзат баг

1.2 Төслийн зорилго, хүчин чадал

Компани 4510 кодтой Гадаад худалдаа эрхлэхээс гадна 4652 кодтой “Сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийн худалдаа” эрхэлдэг бөгөөд энэхүү төсөл нь компанийн үйл ажиллагааг өргөжүүлж, үндэсний баялаг бүтээх, эко орчин бий болгох, ногоон бизнесийн хүрээнд “10 МВт хүчин чадал бүхий хоногт 42 мян.кВт цаг цахилгаан эрчим хүч нийлүүлэх боломжтой батарей хуримтлуурт цахилгаан станц” байгуулах зорилготой.

1.3 Төслийн талбайн байршил

Төслийн талбай нь Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын төвөөс зүүн урагш аймгийн аж үйлдвэрийн зориулалтаар олгогдох газрын бүсэд байршилтай ба өөрийн аймгийн төвөөс 3.3 км, Улаанбаатар хотоос 1100 км зайд алслагдсан байна.



Зураг 1. Төслийн талбайн байршил

Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Харзат баг, Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Засаг даргын 2024 оны 04 сарын 22-ны өдрийн А/51 тоот захирамжаар Харзат багийн Цэвэрлэх “Том Нар Энержи” ХХК-д боловсруулав.

“Том нар энерги” ХХК-ний “Говь-алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт хэрэгжүүлэх 10Мвт/42Мвт цагийн багтаамжтай эрчим хүчний батареи хуримтлуурын төсөл” –ийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

байгууламжийн хойд талд 8208006747 нэгж дугаартай 10,000 м² хэмжээтэй Есөнбулаг сумын ЗДТГ-ын эзэмшилд олгосон газар дээр “Том нар” ХХК “10 МВт-ын хүчин чадалтай эрчим хүчний хуримтлуурын систем байгуулах” төслийг хэрэгжүүлнэ.

Зураг 2. Төслийн бүтээн байгуулалт эхлэхийн өмнөх зураг 2025.05.11



Зураг 3. “Том нар энерги” ХХК-ний “Говь-алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт хэрэгжүүлэх 10Мвт/42Мвт цагийн багтаамжтай эрчим хүчний батареи хуримтлуурын станц” төслийн талбай 2025.10.24

1.4 Алтай-Улиастай эрчим хүчний систем

Алтай-Улиастайн Эрчим Хүчний Систем (АУЭХС) ТӨХК нь 2009 оны 4 дүгээр сараас үйл ажиллагаагаа явуулж Говь-Алтай, Завхан аймгийн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангаж байгаа ба харьяандаа “Есөнбулаг Эрчим Хүч” ХХК, “Тайшир-Гуулин УЦС” ХХК, “Галуутай-Хүнгүйн УЦС” ХХК, “Тосонцэнгэлийн УЦС” ХХК зэрэг 4 компанитай. Тус систем нь Завхан аймаг дахь салбар, Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр бүхий 6 сум, давхардсан тоогоор дизель станцаар 43 сум, 2 тосгоныг эрчим хүчээр хангаж байна. Системийн нийт хэрэглээний 30%-ийг Тайширын усан цахилгаан станц хангадаг ба Говь-алтай аймгийн 5 сумыг 35 кВ-ын Ховдын Дарви шугамаар дамжуулан ББЭХС-ээс цахилгаан эрчим хүч худалдан авч хангаж, тусдаа ажиллаж байна. АУЭХС нь нийт 14 МВт-ын суурилагдсан хүчин чадал бүхий 6 усан цахилгаан станц, 2 дизель цахилгаан станц болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдээс бүтсэн, нийт 34,4 МВт суурилагдсан хүчин чадалтай систем юм.



Зураг 4. Техногений нөлөөллийн бүс дэх төслийн талбайн байршил, 2024 он

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн хийсэн судалгаа, судалгаанаас гарсан бодит үр дүн

№	Судалгааны төрөл, чиглэл	Судалгааны цар хүрээ	Үр дүнд үндэслэсэн бодит шийдлүүд
1	Монгол улсын эрчим хүчний системийн одоогийн байдал	<ul style="list-style-type: none"> Монгол улсын эрчим хүчний суурилагдсан хүчин чадал Монгол улсын цахилгаан хэрэглээний үйлдвэрлэл, тулгамдсан асуудал Эрчим хүчний дотоодын боловсруулалтын технологийн хувилбарууд Импортын эрчим хүчний зайлшгүй шаардлага, түүний сайн, муу талууд Төвийн бүсийн хоногийн болон жилийн цахилгааны ачаалал, график Дамжуулах сүлжээ болон эрчим хүчний түгээлтийн зохицуулалт Эрчим хүчний цаашдын өсөн нэмэгдэх хэрэгцээ, нийлүүлэлтийн таац 	Бизнесийн судалгаагаа хэрэгжүүлэх шийдвэрийг гаргаж баримт бичиг бүрдүүлэхэд түншүүдтэй харилцаж эхэлсэн.
2	Эрчим хүчний хуримтлуурын систем	<ul style="list-style-type: none"> Хуримтлуурын системийн технологи Хуримтлуурын системийн тоног төхөөрөмж, ажиллах зарчим Шаардлагатай засвар үйлчилгээний зайлшгүй үүсэх нөхцөл, эрсдэлүүд Аюулгүй ажиллагааны шаардлага, стандартууд Хөрөнгө оруулалтын олон улсын сонирхол, зээлийн нөхцөлийг судалсан. 	Технологийн олон төрөлт хувилбарыг зэрэгцүүлэн судалж сонголт хийснээр төслийн эдийн засгийн үр ашгийг тооцсон. Анхны хөрөнгө оруулалтыг тооцсон.
3	Алтай-Улиастайн эрчим хүчний системийн судалгаа	<ul style="list-style-type: none"> Бүс нутгийн байгаль цаг уур, газар зүй болон байгаль орчны нөхцөлүүд Алтай-Улиастайн эрчим хүчний байгууламжийн үйл ажиллагаа, хүчин чадал, хэрэглээний хангамж, дутагдал 	Төслийг хэрэгжүүлэх оновчтой байршлыг сонгож хуримтлуурын системийг хэрэглэх төслийг Монголд анх удаа эхлүүлж байна.
4	Монгол улсын эрчим хүчний салбарын эрх зүйн орчин	<ul style="list-style-type: none"> Эрчим хүчний талаар төрөөс баримталж буй бодлого, түүний өөрчлөлт шинэчлэл Эрчим хүчний салбарын үйл ажиллагааны хууль, эрх зүйн зохицуулалт Сэргээгдэх эрчим хүчний салбарын эрх зүйн зохицуулалт 	Төслийн ТЭЗҮ боловсруулж холбогдох яамны шинжлэх ухааны мэргэжлийн зөвлөлд хэлэлцүүлсэн.

“Том нар энерги” ХХК-ний “Говь-алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт хэрэгжүүлэх 10Мвт/42Мвт цагийн багтаамжтай эрчим хүчний батарей хуримтлуурын төсөл” –ийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

5	Тусгай зөвшөөрөл авахтай холбоотой эрх зүйн орчны судалгаа	<ul style="list-style-type: none"> • Байгаль орчны багц хуулиуд, эрх зүйн орчин • Орон нутгийн удирдлага, засаг захиргааны нэгжийн удирлагын тухай хууль, эрх зүйн орчин 	Тусгай зөвшөөрөл авахтай холбоотой баримт бичгийн бүрдүүлбэрийг хангаж эхэлсэн.
---	--	--	---

1.5 Төслийн гол ба болзошгүй нөлөөллийн тодорхойлолт

Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн тодорхойлолт Говь-Алтай аймгийн төв, Есөнбулаг сумын төв зэрэг суурьшлын давхцалын бүсэд эрчим хүчний үйлчилгээ, хангамжийг нэмэгдүүлэх батарей хуримтлуурын систем байршуулах төслийн талбайн бүс нутгийн байгаль болон амьдрах орчны төлөв байдлыг үнэлж үзээд экосистемийн хувьд эрс өөрчлөлттэй, хүн-техник-технологийн хүчин нөлөөнд ихээхэн автсан орчин болсныг дээр өгүүлсэн судалгааны дүнд үндэслэн тогтоосон байна.

Хүснэгт 2. Төслийн бүс нутгийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээ

Нөлөөллийн хүчин зүйлүүд	Төлөв байдлын гол үзүүлэлтүүд	Нөлөөлөл
Газар	<p>Төслийн талбайн орчинд үйлдвэр-аж ахуйн зориулалтаар газар ашиглана.</p> <p>Одоохондоо тархай сийрэгдүү ашиглалттай, дэд бүтцийн байгууламжийн төвлөрөлтэй нь давуу тал болно.</p> <p>Бүс нутаг газар дүрсийн ноцтой өөрчлөлт бүдэг, олон төрлийн үйлдвэр-технологийн үйл ажиллагаа зэрэгцдэг.</p> <p>Төсөл өөрөө эзэмшлийн талбайнхаа 90 гаруй хувийг хатуу хучилттай болгон ашиглана.</p>	Төслийн газар нь үйлдвэртехнологийн бүсэд олгогдсон сайн талтай ч газар олон төрлийн шууд нөлөөллүүд давхацсан нь өөрчлөгдсөн орчиныг үүсгэсэн. Тиймээс Хүний эрүүл мэндийг орчны бохирдлоос хамгаалах шаардлагатай.
Агаар	<p>Төслийн талбай нь нэг талаас суурьшлын бүсийн салхин доор байршиж, нөгөө талаас олон салаа хөрсөн замын дунд орсон байршилтай.</p> <p>Салхины дээдэх суурьшлын бүсээс хорт хийгээр бохирдсон агаараар салхилна.</p> <p>Төсөл өөрөө агаарт бохирдол үүсгэх тоосны болоод хийн ялгарал гаргахгүй.</p>	Төслийн талбай бусад төслийн нөлөөллийн бүсэд орсон байх ба төсөл нь агаарын бохирдлын сөрөг нөлөөг бууруулах шийдэлтэй.
Усан орчин	<p>Төслийн бүс нутагт гадаргын усны нөөц байхгүй.</p> <p>Төсөл хэрэгжүүлэгч технологийн хэрэгцээнд нэрмэл ус ашиглах бөгөөд түүнийг зөөвөрлөн авчирч ашиглана. Зөөврийн нэрмэл усыг худалдаж авна.</p> <p>Төслийн унд ахуйн хэрэгцээний усыг мөн зөөвөрлөн хэрэглэх бөгөөд зөөврийн усыг худалдаж авна.</p>	Төслийн усны хэрэгцээг зөөврөөр хангах бүрэн боломжтой. Төсөл хэрэгжүүлэгч өөртөө заавал усны эх үүсвэртэй байх шаардлагагүй.

“Том нар энерги” ХХК-ний “Говь-алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт хэрэгжүүлэх 10Мвт/42Мвт цагийн багтаамжтай эрчим хүчний батарей хуримтлуурын төсөл” –ийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Хөрс	Төслийн үйл ажиллагаанаас хөрсөнд үзүүлэх нөлөө төслийн талбайгаар хязгаарлагдана. Төслийн эзэмшил газрын хөрсөн бүрхэвчийн 40.0 хувь нь хэдийнээ тахлагдаж эвдэрсэн. Цаашид төслийг хэрэгжүүлэхэд сүйтгэгдэх талбайн хэмжээ 90.0 хувьд хүрнэ. Төслийн талбайн ашиглалтгүй 10.0 хувьд ашиглалтын эрчим сул байна.	Хөрс-ургамал-амьдрах орчинд үүссэн өөрчлөлт болон сөрөг нөлөөллүүд ижил шалтгаантайгаас гадна бие биеэсээ харилцан хамааралтай байна. Тиймээс газрыг хамгаалснаар хөрсийг, хөрсийг хамгаалснаар ургамлыг хамгаалах боломжтой ба хамгааллын зарчим нь байгаль орчны суурь зарчмуудад нийцтэй байх боломжтой.
Ургамлан нөмрөг	Ургамлан нөмрөгт доройтлын индикатор ургамлын хувийн жин зонхилж байгаа ба ургамалгүй талбай хэмжээ төслийн талбайн 60.0 орчим хувьд байна. Цаашид ургамлыг биет хэмжээгээр сүйтгэх үйл ажиллагаа төслийн талбайн 90.0 хувьд хүрнэ. Төслийн талбайн ашиглалтгүй 10.0 хувьд ногоон байгууламж хийх боломжтой.	
Биологийн олон янз байдал	Төслийн талбайг чөлөөлж хатуу хучилттай болгоно. Төслийн талбайн ашиглалтгүй 10.0-д байршуулах ногоон бүсэд бүс олон зүйл ургамал байршуулна.	

1.6 Төслийн орчны нийгмийн төлөв байдал

Эрчим хүчний үйлчилгээ, хангамжийг нэмэгдүүлэх батарей хуримтлуурын систем байршуулах төслийн бүс нутагт нийгмийн өндөр ач холбогдолтой.

- МУ-ын эрчим хүчний аюулгүй байдлыг бэхжүүлж, импортын эрчим хүчний зардлыг бууруулна;
- Нэгдсэн сүлжээний хүчдэл давтамж тогтворжиж хэрэглэгч нар чанартай эрчим хүч ашиглана;
- Хязгаарлагддаг сэргээгдэх эрчим хүчийг хуримтлуулан ашиглана;
- ОХУ-с импортолж байгаа эрчим хүчийг орлоно;
- Орон нутагт ажлын байр нэмэгдэнэ.

Хүснэгт 3. Төслийн орчны нийгмийн төлөв байдал

Нөлөөллийн хүчин зүйлүүд	Төлөв байдлын гол үзүүлэлтүүд	Нөлөөлөл
ТХГН	Төслийн талбайн ойр орон нутгийн хамгаалалтад 50 хүртэл жилээр хамгаалах заалттай 7 газар байна. Орон нутгийн тусгай хамгаалалттай газруудын хамгийн ойр нь 7 км, хамгийн хол нь 41 км байршилтай.	Төслийн үйл ажиллагаанаас тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх сөрөг нөлөө тодорхойлогдоогүй.
Түүх соёлын дурсгалт зүйлс	2022 оны тооллогоор Говь-Алтай аймагт Улсын хамгаалалттай 9, аймгийн хамгаалалттай 33 газрыг бүртгэсэн. Бүртгэгдсэн түүх, соёлын дурсгалуудаас Есөнбулаг суманд олдвор бүртгэгдээгүй.	Сөрөг нөлөөлөл урьдчилсан байдлаар тодорхойлогдоогүй.

“Том нар энерги” ХХК-ний “Говь-алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт хэрэгжүүлэх 10Мвт/42Мвт цагийн багтаамжтай эрчим хүчний батарей хуримтлуурын төсөл” –ийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

<p align="center">Нийгмийн төлөв байдал</p>	<p>Төсөл нь эрчим хүчний алдагдлыг бууруулахад шийдэлтэй нь нийгмийн өндөр ач холбогдолтой.</p> <p>Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн судалгааг 7 жилийн турш нягт нямбайгаар хийж үе шаттай шийдвэрүүдийг гарган хэрэгжүүлж байгаа.</p> <p>Төсөл хэрэгжүүлэгч нь баримт бичиг бүрдүүлбэр нь холбогдох хууль журмын дагуу бүрдсэн.</p> <p>Төслийн бүс нутгийн оршин суугчид нь эдийн засгийн төслүүдийг таньж мэдэх, төсөлд санал оруулах оролцоо бага зэргийн сулавтар.</p>	<p>Төсөл нь орон нутгийн өргөн хэрэгцээт асуудлыг шийдвэрлэнэ гэдгээ төсөл хэрэгжүүлэгч маш сайн ойлгож мэдэрч байгаа нь нэн сайн. Оршин суугчдын оролцоог хангах, тэдний эрх ашигт нийцтэй үйл ажиллагааг төслийн хүрээнд хэрэгжүүлнэ.</p>
---	---	---

1.7 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Эрсдэлийн үнэлгээний матриц. Эрсдэлийн үнэлгээ нь үйл явдлын үр дагавараас тухайн нөхцөл байдалд үүсэх өөрчлөлт болон эрсдэл тохиолдох магадлалын хослол байх тул түүнийг матрицаар илэрхийлэх боломжтой. Эрсдэлийн матриц нь хослуудын харилцан хамаарлаас үүсэх уршигт байдлын эрчмийн түвшинг тодорхойно.

- **Хүснэгт 4. Эрсдэлийг үнэлэх үнэлгээний матриц**

Давтамжийн индекс		Үр дагаварын индекс			
Тохиолдол/жил	Давтамж	А Маш бага	В Бага	С Дунд зэрэг	Д Их
12	Сар бүр				
1/10	Тохиолддог		Дүр зураг 1		
1/100	Нэг удаа тохиолдож болох				Дүр зураг 2
1/1000	Тохиолдол магадлал бага*	Дүр зураг 3		Дүр зураг 5	
1/10000	Бараг тохиолдохгүй*			Дүр зураг 4	
Тэмдэглэгээ					
	Маш бага эрсдэлтэй				
	Хүлцэж болох эрсдэл				
	Эрсдлийг бууруулж болохуйц				
	Эрсдлийг зайлшгүй бууруулах				

*.-төсөл хэрэгжих хугацааны туршид

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг үнэлэхдээ өмнөх шатанд тодорхойлогдсон болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүд, түүний үйлчлэлд өртөх нутаг дэвсгэрийн байгаль орчин, нутгийн оршин суугчид, түүх, соёлын өвд бий болох сөрөг үр дагавар, түүний эрчим, цар хүрээ, шууд болон шууд бус нөлөөллүүд, болзошгүй нөлөөллийг Монгол улсын хууль тогтоомжид заасан болон олон улсын нийтлэг аргуудыг ашиглан үнэлж, тайланд тусгав.

1.8 Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ

1.8.1 Төслийн ерөнхий үнэлгээний дүгнэлт

Төслийн ерөнхий үнэлгээний 12/2749 тоот дүгнэлтийг БОАЖЯ-наас 2024 оны 06 сарын 07ны өдөр төсөл хэрэгжүүлэгчид хүргүүлсэн байна. Тус төслийн нөлөөллийн ерөнхий үнэлгээний гүйцэтгэлээр энэ төсөлд БОННУ-г хийх шаардлагатай гэж үзсэн.

1.8.2 Ерөнхий үнэлгээний дүгнэлтэнд тавьсан шаардлага

Төсөлд хийсэн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтэнд БОННУ-нд баримтлах гол чиглэл болсон онцгойлон анхаарах дараах асуудлууд жагсаасныг тайланд хэрхэн авч үзсэн талаар тайлбар өгөх нь зүйтэй юм.

Хүснэгт 5. Төслийн болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

№	Байгаль орчны үзүүлэлтүүд	Нөлөөлөл			Хугацаа		Давталт		Эрчим		
		Шууд	Шууд бус	Зохицуулах өөрчлөлт	Богино хугацааны	Урт хугацааны	Будаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1. Байгалийн экосистемийн өөрчлөлт											
1	Газрын доорх урсацын өөрчлөлт			X	X			X			X
2	Хөрсний элэгдэл, эвдрэл	X			X			X			X
3	Ургамлын бүтцийн өөрчлөлт	X			X			X			X
4	Амьтдын амьдрах орчинд үзүүлэх		X		X			X			X
5	Уур амьсгалын бичил өөрчлөлт			X	X			X			X
2. Байгалийн нөөц ашиглалт											
6	Газрын гадаргын нөөц, баялаг			X	X			X			X
7	Бэлчээрийн байдал		X		X			X			X
8	Газрын доорх усны нөөц			X	X			X			X
3. Байгаль орчны чанарын өөрчлөлт											
9	Газрын доорх усны чанарын өөрчлөлт			X	X			X			X
10	Гадаргын усны чанарын өөрчлөлт		X		X			X			X
11	Агаарын бохирдол	X			X			X			X
12	Хөрсний бохирдол	X			X			X			X
13	Дуу чимээ, шуугианы нөлөө	X				X		X		X	
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор											
14	Байгалийн үзэсгэлэнт өнгө төр			X	X			X			X
15	Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх			X	X			X			X
16	Тусгай хамгаалалттай газар нутаг			X	X			X			X

№	Байгаль орчны үзүүлэлтүүд	Нөлөөлөл	Хугацаа	Давталт	Эрчим
---	---------------------------	----------	---------	---------	-------

“Том нар энерги” ХХК-ний “Говь-алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт хэрэгжүүлэх 10Мвт/42Мвт цагийн багтаамжтай эрчим хүчний батарей хуримтлуурын төсөл” –ийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

		Шууд	Шууд бус	Зохицуулах өөрчлөлт	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
17	Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх			X	X			X			X
18	Археологи, палентологийн олдворт			X	X			X			X

5. Эдийн засаг, нийгмийн асуудал											
19	Ажлын байр нэмэгдэх	X				X		X		X	
20	Орон нутгийн орлого нэмэгдэх	X				X		X		X	
21	Хувийн өмчийн болон татварын орлого	X				X		X		X	
22	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	X				X		X			X
23	Бүтээгдэхүүн, түүхий эдийн эрэлт	X				X		X			X
24	Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх (оршин суугчид)		X			X		X			X
6. Бусад нөлөөлөл											
25	Ажлын нөхцөл ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх		X		X			X			X
26	Ахуйн хаягдал, хогийн цэгийн зохих шаардлагын дагуу зайлуулж, устгаагүйгээс байгаль орчин бохирдох, эвгүй үнэр гаргах, шавьж үржих	X				X	X		X		
	Дүн	11	5	10	18	8	1	25	1	4	21

ХОЁР. ТӨСЛИЙН ҮЕ ШАТНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ

Менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилт

БОМТ-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагааны хүрээнд 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны хяналт, хамгааллын ажлыг багцалж төлөвлөхөд оршино. БОМТ үндсэн зорилгынхоо хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэнэ.

- Станцын орчинд ногоон бүс тохижуулах
- Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж осол эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авах
- Хог хаягдлын оновчтой менежмент хэрэгжүүлэх
- Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Байгаль орчны хамгаалахад удирдлагын оновчтой бодлого төлөвлөж хэрэгжүүлэх БОМТ-нд олон нийтийн оролцоог хангах зэрэг ажил болно.

Менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ

БОМТ-г боловсруулахад БОАЖСайдын 2019 оны А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, биелэлтийг тайлагнах” журмыг мөрдсөн ба төсөл нь “ХАА, үйлдвэрлэл, аялал жуулчлал, дэд бүтэц”ийн төслийн ангилалд хамаарна.

Хүснэгт 6. БОМТ-г боловсруулахад ашигласан баримт бичгийн жагсаалт

№	Баримт бичгийн нэр	Баримт бичгийн үндэслэл	Шаардлагын тодорхойлолт
1	Алтай-Улиастай эрчим хүчний системд холбогдон ажиллах “10 мвт хүчин чадалтай эрчим хүчний хуримтлуурын систем”ийн техник эдийн засгийн үндэслэл	Төслийн хэрэгжүүлэх техник болон эдийн засгийн үндэслэлийг тодорхойлсон судалгаа, тооцооны баримт бичиг.	Төслийг хэрэгжүүлэх техник ажиллагааг нарийвчлан, технологийн болон менежментийг зардал тооцсон баримт бичиг.
2	ЭХЯамы Шинжлэх ухаан-технологийн зөвлөлийн хурлын тэмдэглэл, 2023-9-20-ны өдрийн V ээлжит хуралдаан	“10 мвт хүчин чадалтай эрчим хүчний хуримтлуурын систем” төслийг дэмжих тухай шийдвэр.	Төслийн хэрэгжих боломжийг тодорхойлсон ЭХ-ний салбарын анхан шатны зөвшөөрөл
3	Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын газрын даамал Б.Дулмаагийн үйлдсэн газрын кадастр зураг	8208005520 тоот нэгж талбарын дугаартай 2381 квад.м. байршил, хэмжээ тодорхойлсон.	Төсөл хэрэгжих газрын газарзүйн байршилыг тодорхойлсон.

“Том нар энерги” ХХК-ний “Говь-алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт хэрэгжүүлэх 10Мвт/42Мвт цагийн багтаамжтай эрчим хүчний батарей хуримтлуурын төсөл” –ийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

4	Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Харзат багийн нутагт хэрэгжүүлэх “10 МВТ хүчин чадалтай эрчим хүчний хуримтлуурын систем” төслийн БОТБУ-ний тайлан	Байгаль орчны судалгаа, үнэлгээний мэргэжлийн “Эртгэч наран” ХХК-д 2023 онд боловсруулсан.	БОТБУ-ний шатанд БОННУ хийх шаардлагатай төслийн ангилалд хамаарч байгааг тогтоосон.
5	Төслийн Ерөнхий үнэлгээний дүгнэлт	БОАЖЯамны 2023-10-27-ны өдрийн 12/5673 тоот албайн бичгээр төсөл хэрэгжүүлэгчид хүргүүлсэн.	БОННУ-г 2024 оны II улиралд багтаан яаманд ирүүлэх тухай шаардлага.
6	Төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланг БОУАӨЯ-ний мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн	БОУАӨЯ-ний 2024 оны 09 сарын 06-ны өдрийн хуралдаанаар БОННУТайланг хэлэлцсэн.	Тайлангийн хурлаар аюултай хог хаягдлыгхэрхэн устгах талаар хууль тогтоожийн хүрээнд ажиллах зөвлөмж өгсөн
7	Төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан	БОАЖЯамны 2024-09-06-ны байгаль орны Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хурлаар танилцуулж баталгаажуулсан.	БОННУ баталгаажсан тайланг 2024 оны 10 сарын 03-ны өдөр хүлээн авсан.

2. Сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт



Зураг 5. Төслийн талбайн байдал 2024.05.01

“Том нар энерги” ХХК-ний “Говь-алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт хэрэгжүүлэх 10Мвт/42Мвт цагийн багтаамжтай эрчим хүчний батарей хуримтлуурын төсөл” –ийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Зураг 6. Хуримтлуурын системийг байршуулсаны дараах байдал 2025.09.25

2.2 Ариутгал халдваргүйжүүлэлт улиралд 1 удаа хийсэн.

2.3 Бүтээн байгуулалтын үед ашигласан энгийн нүхэн жорлонг дарах.

Бүтээн байгуулалтын үед ашигласан нүхэн жорлонг дарах ажил хийгдээгүй. Учир нь бүтээн байгуулалтын ажил 2025 оны 11 сар хүртэл үргэлжилсэн. Мөн удирдлагын байрны бохирын ситемийн ажиллагааг өвлийн улиралд ямар нэгэн доголдол гарч болзошгүй, гүйцэтгэгч компани нь ажлын гүйцэтгэлээ төлөвлөсөн хугацаанаасаа хоцороч дуусгасан зэрэг шалтгаануудаас хамааран гадна байрлаж байгаа нүхэн жорлон ирэх жилийн 1-р хүртэл түр байлгахаар компанийн зүгээс шийдвэрлэсэн. 2026 оны 1-р улиралд багтаан зохих ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж дарах ажлыг зохион байгуулна.

ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

3.12.1 Төслийн талбай дотор хайрган хучилт хийх.

Станцыг бүтээн байгуулж, үйл ажиллагааг эхлүүлэхэд хуримтлуурын системийн шаардлагад нийцүүлэн газар талбайг тэгшилж маш тэгш гадаргатай хайрган хучилт хийх.


Манай компанийн батарей хуримтлуурын станц Алтай Улиастай эрчим хүчний систем 110/35/6 кВт” ТӨХК-ийн “Алтай” дэд станцтай залгаа эрчим хүчний барилга байгууламж бөгөөд төслийн талбайн ил хуваарилах байгууламж болон хүчний трансформаторын суурийн хайрган хучилтын ажлыг 2025 оны 11 сард хийж гүйцэтгэсэн.



Зураг 7. Алтай Улиастай эрчим хүчний систем 110/35/6 кВт” ТӨХК-ийн “Алтай” дэд станцтай залгаа төсөл хэрэгжүүлэх талбайн зураг 2024.10.12



Зураг 8. Хүчний трансформаторын суурийн хэсгийн хайрган хучилтын ажлыг хийж гүйцэтгэсэн. 2025.11.25-ны өдөр



Ил хуваарилах байгууламжийн суурийн хэсгийн хайрган хучилтын ажлыг хийж гүйцэтгэсэн. 2025.11.25-ны өдөр

3.2 Талбай доторх өвс ургамлыг зулгааж хөрсний өнгөн хэсгийг экскаватороор ухаж ковшоор түрж тэгшилсэн.



3.3 Мод бут тарих: Монгол улсын эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрмийн 3-рт “Хамгаалалтын зурваст ажил үйлчилгээ явуулах дүрмийн 3.6 хэсэгт хамгаалалтын зурвас дотор тарьсан мод бут нь шугам сүлжээнд хор хохирол, гэмтэл учруулах буюу үзлэг үйлчилгээ хийхэд саад болох тохиолдолд мод, бут эзэмшигч нь түүнийг шилжүүлэн суулгах, тайрах, огтлох үүрэгтэй” гэж заасан. Компани нийгмийн хариуцлагын хүрээнд сумын ЗДТГ-тай харилцан тохиролцож зааж өгсөн тайлбайд 2026 оны хавар 300 ш мод тарихаар төлөвлөж байна.

ДӨРӨВ. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хуримтлуурын системийн бүс нутагт түүх дурсгалын биет зүйлс тэмдэглэгдээгүй бөгөөд систем нь 2381 квад.м талбай ашиглаж, үүссэн нөлөөлөл нь төслийн талбайгаас гадагшлахгүй тул түүх, дурсгалт зүйлсийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл байхгүй.

ТАВ. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн хэрэгжилтийн хүрээнд гарч болзошгүй эрсдэлүүд: Батарей эрчим хүч хуримтлуурын системийг ашиглах шийдвэрт үнэ, ашиглах боломжтой орон зай, суурилуулалт, ашиглалт, засвар үйлчилгээний хялбар байдал зэрэг хүчин зүйлс нөлөөлнө.

2011-2023 оны хооронд хэд хэдэн томоохон сүлжээний эрчим хүч хуримтлуурын байгууламжид гал гарч, аюулгүй ажиллагааны түвшин сайжруулах үүднээс стандартуудыг илүү боловсронгуй болгож ирсэн туршлага олон улсад бий. Тиймээс батарей хуримтлуур ашиглаж ирсэн улс орнуудын туршлагаас шууд нэвтрүүлэх замаар осол эрсдэлээс сэргийлэх менежментийг төлөвшүүлнэ.

5.1 Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад гарч болзошгүй байгалийн гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.



Зураг 8. Хуримтлуурын системийн орчинд хэрэглэх анхааруулах тэмдгүүд

1 Хүний эрүүл мэндийг хамгаалах.

Ажилчдад хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн тухай ойлголтыг хөдөлмөр хамгааллын сургалтаар дэлгэрэнгүй өгч ослын үед авах яаралтай тусламж, зохион байгуулалттай арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүн нэг бүрийн үүргийг тодорхой болгож заасан байна.

Хүснэгт 9. Цаг агаарын эрсдэлтэй нөхцлөөс үүсэх гэнэтийн осол

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
	Урьдчилан сэргийлэх мэдээ болон дохиолол холбооны найдвартай байдлуудыг байнга хангах	Тухай бүрт	Цаг агаарын урьдчилан сэргийлэх өдөр тутмын мэдээг www.tsag-agaar.gov.mn цахим хаягнаас байнга авч албан мэйлээр болон хэвлэмэл байдлаар самбар дээр байршуулах байдлаар нийт ажилтнуудад анхааруулан ажилладаг.	100%

Компанийн зүгээс хувийн хамгааллын хувцас хэрэгслийг тогтмол хугацаанд шалгаж, шаардлагатай бол шинэчилж, солих арга хэмжээг авч үүнтэй холбоотой зардлыг жил бүрийн үйл ажиллагааны төсөвт суулгаж өгсөн.

Хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалтанд хамруулсан Ажилчдыг галын хор болон бусад хэрэгслийг ашиглаж сургах, дадлага эзэмшүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авсан.



“Том нар энерги” ХХК-ний “Говь-алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт хэрэгжүүлэх 10Мвт/42Мвт цагийн багтаамжтай эрчим хүчний батарей хуримтлуурын төсөл” –ийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

4	Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад гарч болзошгүй гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор тэмдэг, тэмдэглэгээ хийх.	Багц	Эрчим хүчний сайдын 2024 оны 08.22ны 101 тоот тушаалаар батлагдсан Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрмэмд зааснаар аюулгүй ажиллагааны тэмдэг тэмдэглэгээ байршуулах, батарей хуримтлуурын станцын гадна талбайд болон өндөр хүчдэлийн шон хуваарилах байгууламжийн бүх цахилгаан тоноглол дээр болон удирдлагын байрны тоног төхөөрөмжүүд дээр анхааруулах нийт 252 ширхэг тэмдэг тэмдэглэгээг хэвлүүлэн байршуулсан	100%
---	---	------	--	------

 <p align="center">ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ЕСӨНБУЛАГ СУМ 10МВТ/42МВТ ЦАГ БАТАРЕЙ ЭРЧИМ ХҮЧ ХУРИМТЛУУРЫН ТӨСӨЛ</p> <p align="center">БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ӨДӨР ТУТМЫН ТАЙЛАН</p> <p>ТАЙЛАНГИЙН ДУГААР: 250602 ОГНОО: 2025.06.02 ГҮЙЦЭТГЭГЧ: СМАРТ НАЙНУРАЛ ЭНЭРЖИ ХХК, ТОМ НАР ЭНЭРЖИ ХХК</p> <table border="1"> <thead> <tr> <th>1</th> <th>Цаг агаарын мэдээлэл</th> <th>Тайлбар</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1.1</td> <td>Бага зэрэг үүлэрхэг 2 – 16 °С Салхины хурд: 3 - 6 м/с БХ зүгээс Цаг агаарын нөлөөлөл: Ажилд саад учруулсан эсэх</td> <td>Үгүй</td> </tr> <tr> <td>2</td> <td>Ажиллах хүч</td> <td></td> </tr> <tr> <td>2.1</td> <td>1. Барилгын инженер 1 2. ХАБ инженер 1 3. Орлуулагч 1 4. Арматурчин 6 5. Мушан 8 6. Цахилгаанчин 1 7. Туслах ажилчид 4 Нийт 22</td> <td></td> </tr> <tr> <td>3</td> <td>Хийгдсэн ажлууд</td> <td></td> </tr> <tr> <td>3.1</td> <td>1. 8,10 дугаар контайнерийн суурийн хэв, хашмал 2. PCS суурийн арматурчлал 80% 3. PCS суурийн хэв, хашмал, бэхлэгээ 4. Сувагчлалын газрын тэгшилгээ 5. Удирдлагын байрны арматурчлалтын тэмдэглэгээ</td> <td></td> </tr> <tr> <td>4</td> <td>Ирүүлсэн болон, зарцуулсан материал</td> <td></td> </tr> </tbody> </table>	1	Цаг агаарын мэдээлэл	Тайлбар	1.1	Бага зэрэг үүлэрхэг 2 – 16 °С Салхины хурд: 3 - 6 м/с БХ зүгээс Цаг агаарын нөлөөлөл: Ажилд саад учруулсан эсэх	Үгүй	2	Ажиллах хүч		2.1	1. Барилгын инженер 1 2. ХАБ инженер 1 3. Орлуулагч 1 4. Арматурчин 6 5. Мушан 8 6. Цахилгаанчин 1 7. Туслах ажилчид 4 Нийт 22		3	Хийгдсэн ажлууд		3.1	1. 8,10 дугаар контайнерийн суурийн хэв, хашмал 2. PCS суурийн арматурчлал 80% 3. PCS суурийн хэв, хашмал, бэхлэгээ 4. Сувагчлалын газрын тэгшилгээ 5. Удирдлагын байрны арматурчлалтын тэмдэглэгээ		4	Ирүүлсэн болон, зарцуулсан материал		 <p align="center">ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ЕСӨНБУЛАГ СУМ 10МВТ/42МВТ ЦАГ БАТАРЕЙ ЭРЧИМ ХҮЧ ХУРИМТЛУУРЫН ТӨСӨЛ</p> <table border="1"> <tbody> <tr> <td>4.1</td> <td>Материал зарцуулалтыг Ли инженер тооцож өгнө</td> <td></td> </tr> <tr> <td>5</td> <td>Техник тоног төхөөрөмж</td> <td></td> </tr> <tr> <td>5.1</td> <td>Ашиглаагүй</td> <td></td> </tr> <tr> <td>6</td> <td>Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар</td> <td></td> </tr> <tr> <td>6.1</td> <td>Зааварчилгаа: 1. Хөдөлмөр хамгаалал ажлын хувцасаа бүрэн өмсөх 2. Нүхэнд унахаас сэргийлж ажиллах 3. Эргийн шороо нурахаас болгоомжлох 4. Хүчдэлд нэрвэгдэхээс болгоомжлох, анхааруулын бус дотор ажиллах</td> <td></td> </tr> <tr> <td>7</td> <td>Нэмэлт тайлбар</td> <td></td> </tr> <tr> <td>7.1</td> <td>1. Дутуу арматурыг яаралтай ирүүлэх! 2. Бөхлөгээний ЭХВ брусс яаралтай ирүүлэх</td> <td></td> </tr> </tbody> </table>	4.1	Материал зарцуулалтыг Ли инженер тооцож өгнө		5	Техник тоног төхөөрөмж		5.1	Ашиглаагүй		6	Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар		6.1	Зааварчилгаа: 1. Хөдөлмөр хамгаалал ажлын хувцасаа бүрэн өмсөх 2. Нүхэнд унахаас сэргийлж ажиллах 3. Эргийн шороо нурахаас болгоомжлох 4. Хүчдэлд нэрвэгдэхээс болгоомжлох, анхааруулын бус дотор ажиллах		7	Нэмэлт тайлбар		7.1	1. Дутуу арматурыг яаралтай ирүүлэх! 2. Бөхлөгээний ЭХВ брусс яаралтай ирүүлэх	
1	Цаг агаарын мэдээлэл	Тайлбар																																									
1.1	Бага зэрэг үүлэрхэг 2 – 16 °С Салхины хурд: 3 - 6 м/с БХ зүгээс Цаг агаарын нөлөөлөл: Ажилд саад учруулсан эсэх	Үгүй																																									
2	Ажиллах хүч																																										
2.1	1. Барилгын инженер 1 2. ХАБ инженер 1 3. Орлуулагч 1 4. Арматурчин 6 5. Мушан 8 6. Цахилгаанчин 1 7. Туслах ажилчид 4 Нийт 22																																										
3	Хийгдсэн ажлууд																																										
3.1	1. 8,10 дугаар контайнерийн суурийн хэв, хашмал 2. PCS суурийн арматурчлал 80% 3. PCS суурийн хэв, хашмал, бэхлэгээ 4. Сувагчлалын газрын тэгшилгээ 5. Удирдлагын байрны арматурчлалтын тэмдэглэгээ																																										
4	Ирүүлсэн болон, зарцуулсан материал																																										
4.1	Материал зарцуулалтыг Ли инженер тооцож өгнө																																										
5	Техник тоног төхөөрөмж																																										
5.1	Ашиглаагүй																																										
6	Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар																																										
6.1	Зааварчилгаа: 1. Хөдөлмөр хамгаалал ажлын хувцасаа бүрэн өмсөх 2. Нүхэнд унахаас сэргийлж ажиллах 3. Эргийн шороо нурахаас болгоомжлох 4. Хүчдэлд нэрвэгдэхээс болгоомжлох, анхааруулын бус дотор ажиллах																																										
7	Нэмэлт тайлбар																																										
7.1	1. Дутуу арматурыг яаралтай ирүүлэх! 2. Бөхлөгээний ЭХВ брусс яаралтай ирүүлэх																																										

“Том нар энерги” ХХК-ний “Говь-алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт хэрэгжүүлэх 10Мвт/42Мвт цагийн багтаамжтай эрчим хүчний батарей хуримтлуурын төсөл” –ийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан






ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ЕСӨНБУЛАГ СУМ
10МВт/42МВт.цаг БАТАРЕЙ ЭРЧИМ ХҮЧ
ХУРИМТЛУУРЫН ТӨСӨЛ




Аюултай бүсийн зааг



Барилгын талбайд зөвхөн урт ханцуйтай цамц өмсөнө. Сануулга өгөв

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:  ИНЖЕНЕР Ө.ГАНБАТ

Жич: Нэмэлт зургийг Photos0602 үзнэ үү.










Зураг 9. Болзошгүй аюул ослын үед ашиглах бүрэн ажиллагаатай гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, удирдлагын байранд галын буланг байршуулсан. Төслийн талбайд галын сарайг байршуулсан

Ажиллагсдыг ХХАА-ны хувцас хэрэгсэл буюу бээлий, малгай, хамгаалах хэрэгслээр бүрэн хангах, хэрэглүүлж хэвшүүлэх

Компанийн дотоод журмын дагуу ажилчдыг нормын хувцас хэрэгслээр хангаж ажилласан бөгөөд ажилчид нь хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээ тогтмол өмсөж хэвшсэн.



Зураг 10. Ажилчдад олгосон хөдөлмөр хамгааллын хувцас

Улирал	Барааны нэр	Олгосон тоо хэмжээ, ш
Зун	Зуны нимгэн цамц	16
	Зуны өмд	16
	Зуны хүрэм	16
Өвөл	Өвлийн хүрэм	16
	Өвлийн өмд	16
	Гутал өвлийн	16
Нийт		112

Аюултай хог хаягдал буюу Батарейг устгалд оруулах. Төслийг хэрэгжүүлэхэд бусадтай харьцуулахад өндөр үр ашигтай, батарейны эрчим хүчийг хадгалах технологийн дунд тэргүүлэх байр суурь эзэлж байгаа Лити-ион (Li-ion) баттарейг сонгосон ба лити батарей нь илүү урт настай, аюултай засвар үйлчилгээ шаарддаггүй онцлогтой. Тухайлбал:

- LiFePO₄ батарей нь илүү аюулгүй
- LiFePO₄ батарей нь өндөр хүчин чадалтай хэрэглээнд тохиромжтой олон давуу талтай байдаг
- Лити төмрийн фосфатын батарей нь эрчим хүчний нягтрал багатай байдаг □
Environmental impact Low carbon footprint
- Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн хувьд хоргүй зэрэг давуу талуудтай.

Батарей ашиглалтын хугацааг БНХАУ-ын батарей нийлүүлэгч компаниудын мэдээллээр 7-13 жил гэж тодорхойлноос гадна хөрөнгө оруулагч нар эхний 5 жилийн баталгааг өгч байгаа, баталгааны хугацаанд гэмтэлтэй, эмчлэх шаардлагатай батарейг үйлдвэрлэгчид үнэ төлбөргүй засч сэлбэж, задалж өгөхөөр гэрээнд тусгасан. Мөн батарейг дахин сольж эмчилж засварлах чиглэлээр ашиглалтын хугацааг нэмэгдүүлж болох бөгөөд манай төслийн хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 15 жил, бид 20 орчим болно гэж тооцож байна.

Энэ нь батарейг устгалд оруулах хугацааг уртасгаж байгаа хэрэг бөгөөд БОМ-ын энэхүү төлөвлөгөөний хугацаанд батарейг устгалд оруулах шаардлага үүсэхгүй болохыг илтгэж байгаа юм. Төслийн хэрэгжилтийн 2029 оноос цааших хугацаанд батарейг устгалд оруулах асуудал үүсэж болзошгүй бөгөөд тийм нөхцөл байдлыг Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, байгууллагын Дотоод хяналтын системээр илрүүлэх болно. Хяналтын системд өгөгдсөн үзүүлэлтүүд нь станцад суурилагдсан үндсэн тоноглолын ажиллагааг хянахад зориулагдаж үйлчилгээний ажилчид богино хугацаанд засварлах боломжтой гэж төслийн ТЭЗҮ-д авч үзсэн байгаа. Уг станцын ашиглалтын үеийн хамгаалалт, хяналт, шинжилгээний систем нь доорх зүйлээс бүрдэнэ. Үүнд:

1. Видео ажиглалт
2. Батарей менежмент систем /батарейны бүхий л мэдээлэл агуулагдана/
3. Батарей хуримтлуурын станцын цэнэглэлт болон үйлдвэрлэл үр ашиг
4. Үр ашгийн оновчлол
5. Алсын удирдлага



“Том нар энерги” ХХК-ний “Говь-алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт хэрэгжүүлэх 10Мет/42Мет цагийн багтаамжтай эрчим хүчний батарей хуримтлуурын төсөл” –ийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

ЗУРГАА. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 13. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
1	Хатуу хог хаягдлын сав байршуулах	1 ш	Ахуйн хатуу хог хаягдлын түр хадгалах цэгийг стандартын шаардлагад нийцүүлэн битүүмжлэл сайтай, галд тэсвэртэй материалаар төмөр хийцлэлтэй	100%
2	Мэдээлэл сурталчилгаа хийх, тэмдэгжүүлэх	Төслийн хугацаанд	Хог хаягдлын цэгүүдийг бүрэн тэмдэгжүүлсэн бөгөөд шаардлагатай мэдээллийг өдөр бүрийн зааварчилгаан дээр ажилтнуудад өгдөг.	100%
3	Ангилж ялгасан дахин боловсруулах боломжтой ахуйн хатуу хог хаягдлыг дахиврын үйлдвэрт нийлүүлэх, боловсруулах боломжгүй хэсгүүдийг зайлуулах гэрээг эрх бүхий этгээдтэй хийх	-	Хог хаягдлын гэрээг Алтай хотын тохижилт үйлчилгээний газар ААТҮГ-тай гэрээ байгуулан хог хаягдлыг ачуулах ажлыг гүйцэтгэж байна.	100%



ДОЛОО. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Сөрөг нөлөөллийн хяналтын цэгүүдийг байршуулах Сөрөг нөлөөллийн тархалт, эрчмийг хянаж байх зорилготой орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах асуудлуудыг хамруулна. Үүнд:

- Экологийн хяналт, удирдлагын арга хэмжээ
- Засвар үйлчилгээний үед ялгарах, алдагдах хүхрийн хүчлээс хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад тавих шаардлага
- Хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад тавигдах шаардлагыг хангахад орчны хяналт шинжилгээг чиглүүлнэ.



Зураг 12 Сөрөг нөлөөллийн тархалт, эрчмийг хянаж байх зорилготой орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээ

Хүснэгт 14. Сөрөг нөлөөллийн тархалт, эрчмийг хянаж байх зорилготой орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байдал


	Төлөвлөсөн арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
1	Агаар бохирдуулагч бодис, SO_2 мг/м ³ , NO^2 мг/м ³ , /TSP/мг/м ³ , нийт тоосонцор Батарей хуримтлуурын станцын хашаанд Тоосонцорын хэмжилтийг өдөрт 3 удаа цуглуулах хэмжилт хийгдсэн.	Улиралд 1 удаа	Өглөө өдөр оройн цагуудад авсан шинжилгээг Говь-Алтай аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн байгаль орчны шинжилгээний лабораторийн шинжээч Д. Сарантуяа, техникч С. Янжмаа нар ирж ажиллав	100%
2	Хөрсний нянгийн бохирдол Хөрсний хүнд металлын бохирдол	Улиралд 1 цэгт	Хөрснөөс дээж авч Ланд Овнер компанийн “Грийн лаб” лабораторид шилжилүүлсэн.	100%
3	Зөөврийн усыг Говь-Алтай аймгийн “Ундрага-Алтай ААТҮГтай байгуулан ажиллаж байна.	Улиралд 1 удаа	Говь-алтай аймгийн стандарт хэмжил зүйн Хэлтсийн итгэмжлэгдсэн сорилтын лабораторид шинжилүүлсэн	100%

Хавсралт 1. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд байгаль орчны бүрдэл хэсгүүд тус бүр дээр хэмжилт, дээжлэлт хийж буй агшныг баталгаажуулсан, төсөл хэрэгжиж буй орчны фонтой хамт авсан гэрэл зураг










Хөрсний хувийн цахилгаан эсэргүүцлийн туршилт



Хөрсний хувийн цахилгаан эсэргүүцлийн туршилт

Цахилгаан станцын барилгын талбай



“Том нар энерги” ХХК-ний “Говь-алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт хэрэгжүүлэх
10Мет/42Мет цагийн багтаамжтай эрчим хүчний батарей хуримтлуурын төсөл” –ийн 2024
оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд байгаль орчны бүрдэл хэсгүүд тус бүр дээр хэмжилт, дээжлэлт хийж буй агшныг баталгаажуулсан, төсөл хэрэгжиж буй орчны фонтой хамт авсан гэрэл зураг, шинжилгээний үр дүн

УС,ЦАГ УУР,ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Тоос, тоосонцрын шинжилгээний дүн

Дугаар он/№ : 2025/13
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “ТОМ НАР ЭНЕРЖИ” ХХК
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : БОШЛ-ийн шинжээч С.Янжмаа
Дээжийн тоо, төрөл : 1.Тоос
Хүлээн авсан огноо : 2025.10.24
Дээжийн тодорхойлолт : Дэд станцын гадна тал
Шинжилсэн огноо : 2025. 10.24
Хуудасны тоо : 1/1
Үр дүн

Агаар бохирдуулагч бодис	Нийт тоос /TSP/ мг/м ³
Дундаж	190
Их	6150
Бага	65
MNS 4585:2025	500

Баталгаажуулсан:
УЦУОШТ-ийн дарга *[Signature]* Н.Алтантуяа
Хянасан:
БОШЛ-ийн эрхлэгч *[Signature]* Д.Сарантуяа
Шинжилгээ гүйцэтгэсэн:
БОШЛ-ийн техникч *[Signature]* С.Янжмаа



**“Том нар энерги” ХХК-ний “Говь-алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт хэрэгжүүлэх
10Мет/42Мет цагийн багтаамжтай эрчим хүчний батарей хуримтлуурын төсөл” –ийн 2024
оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

**УС,ЦАГ УУР,ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ**

АГААРЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

Дугаар он/№ : 2025/22
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “ТОМ НАР ЭНЕРЖИ” ХХК
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : БОШЛ-ийн шинжээч С.Янжмаа
Дээжийн тоо, төрөл : Агаар-1
Хүлээн авсан огноо : 2025.10.24
Дээжийн тодорхойлолт : “Дэд станц” гадна тал
Шинжилсэн огноо : 2025.10.27
Хуудасны тоо : 1/1

Сорьцын нэр	Өдөр	Цаг	Даралт, мм	Температур, °C	салхи зүг, градус	хурд, м/с	Чийг, %	Цаг агаарын байдал	Их хурд, м/с
“Дэд станц” гадна тал	2025.10.24	08	593.6	-15.8	ӨБӨ	2	68	униар	3
		14	593.8	-2.7	ББХ	2	41	үзэгдэлгүй	2
		20	593.8	-8.9	ББХ	4	24	униар	5

Агаар бохирдуулагч бодис	SO ₂ мкг/м ³	NO ₂ мкг/м ³
MNS4585:2016	450	200
дундаж	35	78



УЦУОШТ-ийн дарга..... Н.Алтантуяа

БОШЛ-ийн эрхлэгч..... Д.Сарантуяа

Шинжилгээ гүйцэтгэсэн:

БОШЛ-ийн шинжээч..... С.Янжмаа

Шинжилгээний дүн нь зөвхөн тухайн шинжилсэн дээжинд хүчинтэй.
Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.



“GREEN LAB”
ХӨРС, УСНЫ ЛАБОРАТОРИ



СОРИЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС

Дээж ирсэн огноо: 2025.03.18-22

Шинжилгээ хийлгэж буй байгууллага, хувь хүн: “Том Нар Энержи” ХХК

Холбоо барих дугаар: 95261119

Дээж авсан газар: Говь-Алтай аймаг Есөнбулаг сумын Харзат баг Алтай дэд станцын залгаа БХС-ийн төсөл

Хөрсний химийн задлан шинжилгээний дүн / MNS3310:1991/

№	Лаб №	Дээжний нэр	Гүн см	рН	Давс, %	ЦДЧ	СаСО ₃ %	Ялзмаг %	Шингээгдсэн сууриуд, мг-экв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
									Са	Mg	P ₂ O ₅	K ₂ O
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	25/1725	Дээж-1	0-20	8.72	0.08	0.154	3.48	2.72	9.2	1.4	1.4	21

Хөрсний механик бүрэлдэхүүн /MNS 6824:2020/

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
				2.0-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
1	25/1725	Дээж-1	0-20	36.6	35.9	14.3	3.6	7.0	2.5	13.1

Хөрсний хүнд металл /MNS ISO 11466:2007/

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Хүнд металл мг/кг					
				Cd /Кадми/	Cr /Хром/	Ni /Никель/	Pb /Хар тугалга/	Zn /Цайр/	Cu /Зэс/
1	25/1725	Дээж-1	0-20	-	25.5	15.4	44.4	38.9	20.6
Шавранцар хөрсний зөвшөөрөгдөх дээд хэмжээ				1.5	100.0	100.0	70.0	150.0	100.0
Элсэнцэр хөрсний зөвшөөрөгдөх дээд хэмжээ				1.0	60.0	60.0	50.0	100.0	60.0
Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт				/MNS 5850:2019/					

Жич:Шинжилгээний хариу нь зөвхөн тухайн цэгийн дээжинд хамаарах ба хувиан олшруулахыг хориглоно

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН:

Шинжээч:

/С. Мягмардаш/

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:

Лабораторийн эрхлэгч

Г.Ганчимэг /M.Sc /

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 9-р хороо, Алтайн гудамж 5 давхар оффис 2 давхар 243 тоот Утас/Факс : 72702020, 88950626 E-mail: landownermongolia@gmail.com



“GREEN LAB ”
ХӨРС, УСНЫ ЛАБОРАТОРИ



СОРИЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС

Дээж ирсэн огноо: 2025.03.18-22

Шинжилгээ хийлгэж буй байгууллага, хувь хүн: “Том Нар Энержи ” ХХК

Холбоо барих дугаар: 95261119

Дээж авсан газар: Говь-Алтай аймаг Есөнбулаг сумын Харзат баг Алтай дэд станцын залгаа БХС-ийн төсөл


Хөрсний эрүүл ахуй / MNS 6341:2012, MNS 5367:2004, MNS 6341:2012/

№	Лаб №	Дээжний нэр	Нянгийн тоо		Гэдэсний савханцарын титр (E.Coli)		Анаэробын титр (Cl.perfringens)	
			Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	
1	25/1725	Дээж-1	2.8*10 ⁴	1.0	Цэвэр	0.1<	Цэвэр	

Жич:Шинжилгээний хариу нь зөвхөн тухайн цэгийн дээжинд хамаарах ба хувиан олшруулахыг хориглоно.

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН:

Шинжээч:



Л. Гэрэлтуяа/

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:

Лабораторийн эрхлэгч



Г.Ганчимэг /M.Sc /

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 9-р хороо, Алтайн гудамж 5 давхар оффис 2 давхар 243 тоот
